# СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 05 өдөр Дугаар А/72 Улаанбаатар хот

Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 25 дугаар зүйлийн 25.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг 1-ээс 64 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/158, 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/108, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/06, 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/77, 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/78, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/90, 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/147, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/129, 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/130, 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/41, 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/62, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар баталсан Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг хүчингүйд тооцсугай.

3. Техникийн хорооны Дарга, гишүүдээс "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"–ийг тухай бүр гаргуулан, Стандартчиллын техникийн болон дэд хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажиллахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар (Д.Даваасүрэн)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.УУГАНБАЯР

ХТУ3154 9020030641 9096035

130000780

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 04. дүгээр сарын 05 -ний өдрийн А/172 дугаар тушаалын 43 дугаар хавсралт

Иргэний нисэхийн стандартчиллын техникийн хорооны бүрэлдэхүүн (ТХ 34)

| | | |
|---|---|---|
| Дарга: | Д.Баатар | Агаарын тээвэрлэгчдийн холбооны сургалтын хорооны дарга, Ерөнхий зориулалтын нисэхийн холбооны хяналтын хорооны дарга |
| Жинхэнэ гишүүд (P): | Ө.Одгэрэл | Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, стандартын хэлтсийн ахлах шинжээч |
| | Ч.Мөнхтуяа | Зам, тээврийн хөгжлийн яамны Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга |
| | Д.Уртнасан | Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигацийн үйлчилгээний газрын мэргэжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | Г.Мөнхболд | Иргэний нисэхийн ерөнхий газрын Аэродром агаарын навигацийн хяналтын хэлтсийн дарга |
| | Н.Батсайхан | Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга |
| | Б.Ренчинноров | Төв аймгийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч |
| | Б.Ганбаатар | Монголын нислэгийн удирдагчдын холбооны тэргүүн |
| | Ж.Батбэх | Монголын аэронавигацийн инженер техникийн ажилтнуудын холбооны тэргүүн |
| | Я.Энхбаяр | Нислэгийн техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны нислэгийн хөдөлгөөний шинжээч |
| | Б.Гантулга | "МИАТ" ХХК-ийн Үйлдвэрлэлийн газрын дарга |
| | Г.Хангал | "МИАТ" ХХК-ийн Газрын үйл ажиллагааны менежер |
| | С.Батмөнх | "МИАТ" ХХК-ийн Агаарын хөлгийн засвар үйлчилгээний ерөнхий менежер |